

Хотын нийгэм хангамжийн удирдах төв байгууллага

1931-1-9-нд Засгийн газрын эрхлэх товчооны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлээр Улаанбаатар хотын захиргааны дэргэд орон сууцны тухай аж ахуйг үүсгэн байгуулж түүний ажиллах журмыг тогтоожээ.

1931-1-9-нд Засгийн газрын эрхлэх товчооны хурлаар хотод орон сууцны нөөц бэлтгэлтэй болох тухай тогтоол гаргажээ

1937 онд хот захирах яамнаас эрхлэн зуслангуудыг зохиожээ

1946-6-15-нд нийслэлийн хөдөлмөрчдийн анхдугаар их субботник эхэлжээ.

1950-4-7-нд Сайд нарын Зөвлөл, Намын Төв Хорооны 54/14 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны харьяанд 1943 онд байгуулагдсан Түлээний трестийг 1950-4-15-нд татан буулгахаар тогтоожээ.

1956-1-20-нд Сайд нарын Зөвлөлийн 9 дүгээр тогтоолоор нас барагсдын хүүр оршуулах товчоог Улаанбаатар хотод 1956-3-1-нээс байгуулахаар тогтоосон 1957 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөөний илтгэлд Улаанбаатар хотод нийтдээ 14000 дөрвөлжин метр талбайтай 500 гаруй айлын сууц ашиглалтад орно гэжээ.

1959-9-19-нд Сайд нарын Зөвлөлийн 363 дугаар шийдвэрээр Налайхын тосгоны арилгыг ашиглалтад шилжүүлэн өгөх комиссыг баталжээ.

1959 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн илтгэлд 1959 онд 80000 хавтгай дөрвөлжин метр талбайтай сууцыг ашиглалтад орууллаа. Хотын дулаацуулах системийн анхны ээлж 28 км хоолой , 15 км урт ус түгээгүүрийн барилга ашиглалтад орсон гэжээ.

1960-9-7-нд Сайд нарын Зөвлөлийн 396 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын нийгэм ахуйн зарим чухал арга хэмжээ авчээ.

1962-5-11-нд Сайд нарын Зөвлөлийн 247 дугаар тогтоолоор хөдөлмөрчдөөс орон сууцыг хоршооллож барих ба ашиглах журмын талаар заагаад орон сууцны хоршооллын үлгэрчилсэн дүрэм, зээллэгээ олгох журмын тухай дүрмийг тус тус баталсан юм.

1963-12-26-нд сайд нарын Зөвлөлийн 593 дугаар тогтоолоор Аж үйлдвэрийн комбинатын ус түгээгүүрийн бүх барилга байгууламжийг Улаанбаатар хотын захиргаанд шилжүүлжээ.

1964-12-11-нд Сайд нарын Зөвлөлийн 536 дугаар тогтоолоор улс, хоршооллын орон сууцны ашиглалтын дүрмийг батлаад 1958 оны 431-р тогтоолоор батлагдсан дүрмийг хүчингүй болгожээ.

1965-7-23-нд Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 246/276 дугаар тогтоолоор нийгэм хангамжийн аж ахуй, ахуй үйлчилгэний хүрээнд дор дурдсан зүйлийг хамааруулахаар тогтоожээ.

-Орон сууцны аж ахуй

- Цахилгаан ба дулаан хангамж, шугам сүлжээ.
- Хотын доторх тээвэр
- Ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ
- Хот тохижуулалт
- Ахуй үйлчилгээ
- Түлшний аж ахуй
- Зочид буудал
- Хотын дэвсгэр газрын аж ахуй гэжээ.

1965-9-22-нд Сайд нарын Зөвлөлийн 348 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын угаалгын төв газрыг 1965 оны 4 улиралд аж ахуйн тооцооны үндсэн дээр байгуулан ажиллуулахаар тогтоожээ.

1965-10-20-нд Сайд нарын Зөвлөлийн 380 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод хаягдал цэвэрлэх станцыг 1965 онд багтаан аж ахуйн тооцооны үндсэн дээр нийгэм хангамжийн газрын харьяанд байгуулж, түүнд тус хотын төв парк, цэцэрлэг гудамж талбайг цэвэрлэх, хог хаягдлыг нэгдсэн журмаар ялган устгах үүргийг хариуцуулахаар тогтоожээ.

1966-10-12-нд Сайд нарын Зөвлөлийн 370 дугаар тогтоолоор нийслэлийн 12 дугаар хороололд баригдаж байгаа дулаацуулгын станцын захиргаа байгуулахаар тогтоожээ.

1968-3-15-нд Сайд нарын Зөвлөлийн 79 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын орон сууцны захиргааг 1968-3-15-наас татан буулгаж, түүний үүргийг хотын нийгэм хангамжийн аж ахуйг удирдах газар болон орон сууцны конторт хариуцуулан, материалын контор байгуулахаар тогтоожээ

1968-8-11-нд Сайд нарын Зөвлөлийн 284 дүгээр тогтоолоор “Нийгэм хангамжийн аж ахуй” -г “Нийтийн үйлчилгээний аж ахуй” болгон нэрлэсэний гадна Улсын төвлөгөөний комиссд нийтийн үйлчилгээний аж ахуйн хэлтэс байгуулсан юм. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг удирдах газар гэж нэрлэх болгожээ.

1972-2-25-нд Сайд нарын Зөвлөлийн 57 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээний аж ахуйг удирдах газрын харьяа үсчин, угаалга, гэрэл зургийн газар, халуун усны захиргаа зэрэг ахуй үйлчилгээний байгууллагыг үйлдвэрийн хоршооллын харьяанд байсан ахуй үйлчилгээний комбинаттай нэгтгэж ахуйн тооцоон дээр ажиллуулах.

Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа, үйлдвэрийн хоршооллын бусад байгууллагын бүрэлдэхүүнд байсан нийтийн аж ахуй орон сууцны байгууллагыг Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээний аж ахуйг удирдах газарт харьяалуулан, түүнийг Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг удирдах газар гэж нэрлэх. үйлдвэр хоршооллын төв зөвлөлийн харьяа барилгын артелиг Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээний аж ахуйг удирдах газрын харьяа барилга засварын ангитай нэгтгэж нийтийн орон сууцны барилга засварын контор болгон Нийтийн аж ахуй, үйлчилгээний яаманд харьяалуулжээ. 1972-2-25-нд Сайд нарын Зөвлөлийн 58 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын ахуй үйлчилгээний удирдах газрыг Нийтийн ахуй, үйлчилгээний яамны харьяа газар гэж тогтоожээ.

1974-8-2-нд Сайд нарын Зөвлөлийн 289 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын ахуй үйлчилгээний удирдах газрын харьяа монгол гутал үйлдвэрлэх цехийг малчдын хэрэгцээнд зориулан монгол гутал, гөлөм, дэвс, төрөл бүрийн эмээл, сур, дээсэн эдлэл үйлдвэрлэх бие даасан үйлдвэр болгон 1975-1-1-ннэс өргөтгөн зохион байгуулахаар тогтоожээ.

1977-12-25-нд Сайд нарын Зөвлөлийн хэрэг эрхлэх газрын тусгай хэлтсээс гаргасан жагсаалтад

- Улаанбаатар хотын орон сууц нийтийн аж ахуйг удирдах газар

-Улаанбаатар хотын ахуй үйлчилгээний удирдах газрыг тус тус Нийтийн аж ахуй үйлчилгээний яамны харьяа газар гэж гаргасан байв.

1977-11-18-нд Сайд нарын Зөвлөлийн 321 дүгээр тогтоолоор Налайх хотын нийтийн аж ахуйн товчоо, ахуй үйлчилгээний комбинат, ус сувгийн ангийн захиргааг нэгтгэн тэдгээрийн орон тоонд багтаан 1978-1-1нээс эхлэн нийт аж ахуй үйлчилгээний газар байгуулж аж ахуйн тооцоон дээр ажиллуулахаар тогтоожээ

1977-11-18-нд Сайд нарын Зөвлөлийн 322 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газрын сантехник, гэр ахуйн хэрэгсэл, цахилдгаан лифтийн засвар үйлчилгээний ангид усан халаалтын зуухны ашиглалт, засвар үйлчилгээний хэсэг, механик цехийг 1978 оноос байгуулахаар тогтоожээ.

Одоо нийслэл хот холбоо, харилцаа, цахилган хангамжийн олон мянган километр урт хос зэрэгцээ ба өндөр нам хүчдэлийн кабель шугам, бүхэл бүтэн район хорооллуудыг хамарсан хотын ус түгээгүүрийн, ариутгах татуургын болон дулаалцуулан байгуулалтын янз бүрийн хүчин чадалтай хоолой шугамтай, биологийн болон механик, цэвэрлэгээний иж бүрэн барилга байгууламж бүхий олон зуун сая төгрөгийн өртгөтэй газар доорхи аж ахуйн цоо шинэ бүхэл системтэй боллоо. Газар доорхи аж ахуй ингэж түргэн хурдацтай хөгжсөн нь нийслэл хотын гоо сайхан оршин суугчдын ахуйн соёлд нэг ёсондоо хувьсгал хийсэн юм.